

НАМЫН АРДЧИЛЛААС ДАРГЫН ЗАСАГЛАЛ: ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛЭЭС УХРАХ УУ?

Эрдэнэбилэгийн ГЭРЭЛТ-ОД, МУБИС-ийн НХУС-ийн багш, улс төр судлаач,
доктор, дэд профессор

НЭГ. ОРШИЛ.

Монгол Улс олон намт ардчилсан тогтолцоог сонгосноос хойш эдүгээ 36 жил өнгөрчээ. Гэвч улс төрийн намын төлөвшил хангалтгүй байсаар ирсэн нь намын эрх зүйн зохицуулалт сул байсантай холбоотой. Анхны Улс төрийн намуудын тухай хуулийг 1990 онд баталж байсан бол дараа нь 2005, 2023 онуудад уг хуулийг шинэчлэн найруулж баталсан юм. 1990 оны анхдагч хууль олон намт тогтолцооны эрх зүйн үндсийг тавьсан бол 2005 оны шинэчилсэн найруулга намыг нүсэр бүтэцтэй, масс гишүүнчлэлтэй байхыг дэмжиж, дотоод ардчилал, санхүүгийн үйл ажиллагааг нь хяналтгүй орхисон юм. Өнөөдөр ч иргэд улс төрийн намд итгэхгүй байгаа нь үүнтэй шууд холбоотой юм.

Харин 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд “нам бодлогын байх, дотоод ардчилалтай, хөрөнгө, орлого, зарцуулалт нь нийтэд ил тод байх”-ыг хуульчилсан. Үүний дагуу 2023 онд Монгол Улсын Ерөнхийлөгч хуулийн төслийг санаачилж, улс

төрийн намууд зөвшилцсөнөөр Улсын Их хурал Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг шинэ үзэл баримтлалтайгаар баталсан билээ. Уг хууль 2024 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2026 оны 1 дүгээр сараас бүрэн мөрдөгдөж байна.

Шинэчилсэн хууль нь улс төрийн намуудын өмнө тулгамдсан бүх асуудлыг нэг мөр шийдэж чадаагүй ч Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх эрх зүйн томоохон шинэчлэлийг эхлүүлсэн юм. Ямартаа ч иргэдийн хүлээлт, шийдвэр гаргагчдын ашиг сонирхлын зааг дээр амаргүй замыг туулж, дөрвөн парламент дамжин хэлэлцэж, батлагдсан.

Гэвч хууль хэрэгжиж эхлээд удаа ч үгүй байхад буюу 2024 оны 11 дүгээр сард ИЗНН тэргүүтэй долоон нам уг хуулийн хэрэгжилтийг хойшлуулах хүсэлтийг УИХ-д гаргаж, хэвлэлийн бага хурал хийсэн.¹ Ингээд УИХ-аас Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулж,

¹ “Хуулийн хэрэгжилтийг хойшлуулахгүй бол Монголд нам үлдэхгүй,” News.mn, 2024.11.27, <https://news.mn/r/2766504/>

Түлхүүр үг: Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль, намын дотоод ардчилал, санхүүжилт, орлогын нэг данс, хандив, төсвийн соёл,

намууд дүрэм, хөтөлбөр, зохион байгуулалтаа хуульд нийцүүлэх хугацааг нэг жилээр сунгаж шийдвэрлэсэн. Мөн МАН уг хуульд өөрчлөлт оруулах төсөл боловсруулан 2025 оны 9 дүгээр сард УИХ-д өргөн барьсан² бөгөөд төслийг УИХ 2026 оны хаврын чуулганаар хэлэлцэхээр төлөвлөөд байна.³ Үүнтэй холбогдуулан уг хуулийн төсөлд тусгагдсан өөрчлөлтүүдээс үүсэх институцийн үр дагаврыг Нээлттэй Нийгэм Форум (ННФ) 2025 онд бодлогын шүүмж, дүн шинжилгээгээрээ тусгайлан хөндсөн байдаг.⁴

Харин саяхнаас УИХ уг хуулийн төслийг хэлэлцэх дөхөхөд АН Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг бие даан боловсруулж, УИХ-д өргөн барихаар бэлтгэж эхэллээ. Энэ төсөл Монгол Улсын улс төрийн намуудын төлөвшилд институцийн дэвшил авчрах уу, эсвэл системийн ухралт авчрах уу гэдгийг ардчилал, засаглалын онолын үүднээс судлах шаардлага үүсээд байна.

АН-аас боловсруулсан хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр,

Улаанбаатар хот

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.2.2.1, 17.2.2.2 дахь заалт нэмсүгэй: “17.2.2.1. Төлөөллийн төв байгууллагын гишүүдийн дийлэнх олонхын саналаар шинээр болон нөхөн сонгогдсон төлөөллийн төв байгууллагын гишүүдийг батламжилж болно. 17.2.2.2. Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн олонхын саналаар хяналтын байгууллагын гуравны нэг хүртэлх гишүүдийг намын Даргын санал болгосноор чөлөөлөх, сонгох тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно.”

2 дүгээр зүйл. Улс төрийн намын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай: “26.7. Нам энэ хуулийн 26.1-д заасан орлогыг хүлээн авах намын төв, аймаг, нийслэл, дүүргийн намын байгууллага тус бүрд банкны нэг данстай байна. Нам өөр харилцах данстай байхыг хориглоно.”

3 дугаар зүйл. Улс төрийн намын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийн “12” гэснийг “120” гэж, 33 дугаар зүйлийн 33.7 дахь хэсгийн “50” гэснийг “500” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Улс төрийн намын тухай хуулийн 33 дугаар зүйлийн “33.8” дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн “34.6.12” дахь заалтыг тус тус хассугай. .

Гарын үсэг

² “Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барилаа,” Parliament.mn, 2025.09.26, <https://www.parliament.mn/nn/75750/>

³ Монгол Улсын Их Хурал. (2025). Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай (Тогтоол №126). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (Legalinfo.mn). Төрийн ордон, Улаанбаатар. Цахим хаяг: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17435085372392>

⁴ Нээлттэй Нийгэм Форум. (2025). Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд өгөх шүүмж (Хуулийн шүүмж №50). Улаанбаатар. Цахим хаяг: <https://forum.mn/post/168670>

ХОЁР. ХҮЧИНТЭЙ ХУУЛЬ БОЛОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСЛИЙН ХАРЬЦУУЛСАН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Ардчилал, засаглалын онолын үүднээс АН-ын үүсэх институцийн эрсдэлийг дараах байдлаар өргөн барьсан хуулийн төслийн заалт бүрийг тодорхойлж байна. одоо мөрдөгдөж буй хуультай харьцуулан

Хүчинтэй заалт (2023 оны хууль)	Төслийн найруулга (АН-ын төсөл)	Институцийн болон засаглалын эрсдэл
Шинэ заалт	17.2.2.1. Төлөөллийн төв байгууллагын гишүүдийн дийлэнх олонхын саналаар шинээр болон нөхөн сонгогдсон төлөөллийн төв байгууллагын гишүүдийг батламжилж болно.	Кооптаци (Дээрээс томилох хуйвалдаан) үүсэх эрсдэл: Анхан шатны гишүүдээс дэвшсэн хүмүүсийг дээрээс нь шигшиж, намыг хаалттай клуб (Cartel party) болгох, намын удирдлагын явцуу хүрээллийг зориудаар тэлэх эрсдэлтэй.
Шинэ заалт	17.2.2.2. Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн олонхын саналаар хяналтын байгууллагын гуравны нэг хүртэлх гишүүдийг намын Даргын санал болгосноор чөлөөлөх, сонгох тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно.	Хяналтын механизмыг устгах эрсдэл: Намын дотоод шүүх болох Хяналтын ерөнхий хорооны хараат бус байдал алдагдана. Намын дарга өөрийг нь хянах үүрэгтэй хорооны гишүүдийг өөрөө томилж, чөлөөлөх хөшүүрэгтэй болсноор нам "дарга төвтэй" хаалттай бүлэглэл болно.
26.7. Нам орлогоо зөвхөн нэг банкны дансаар хүлээн авах бөгөөд өөр харилцах данстай байхыг хориглоно.	26.7. Нам энэ хуулийн 26.1-д заасан орлогыг хүлээн авах намын төв, аймаг, нийслэл, дүүргийн намын байгууллага тус бүрд банкны нэг данстай байна. Нам өөр харилцах данстай байхыг хориглоно.	Санхүүгийн ил тод байдал сулрах эрсдэл: Орон нутгийн салбаруудад орлогын данс нээхийг зөвшөөрөх нь практик үйл ажиллагаанд дөхөм боловч СЕХ болон Төрийн аудитаас тавих санхүүгийн нэгдсэн хяналтыг сулруулж, аудитын чанарыг бууруулна.
33.6. Нэг жилд нэг иргэнээс авах хандивын дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс илүү байхыг хориглоно. (Одоогоор дээд хязгаар: 9,504,000 ₮)	33.6. 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийн "12" гэснийг "120" гэж өөрчилсүгэй.	Плутократи (Мөнгөтэй хүмүүсийн засаглал) тогтох эрсдэл: Иргэний хандивын таазыг 10 дахин өсгөж, 95,040,000 төгрөг болгож байна. Энэ нь чинээлэг бүлэглэлүүд иргэний нэрээр намыг санхүүгийн хувьд хараат болгох сувгийг нээнэ.
33.7. Нэг жилд нэг хуулийн этгээдээс авах хандивын дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс илүү байхыг хориглоно. (Одоогоор дээд хязгаар: 39,600,000 ₮)	33.7. 33 дугаар зүйлийн 33.7 дахь хэсгийн "50" гэснийг "500" гэж тус тус өөрчилсүгэй.	Улс төрийн авлига хууль ёсны болох эрсдэл: Компанийн хандивыг 10 дахин өсгөж, 396,000,000 төгрөг болгож байна. Хагас тэрбум шахам төгрөг хандивласан компаниуд ирээдүйд төрийн бодлогыг худалдан авах нөхцөл бүрдэнэ.

Хүчинтэй заалт (2023 оны хууль)	Төслийн найруулга (АН-ын төсөл)	Институцийн болон засаглалын эрсдэл
<p>33.8. Хуулийн этгээдийн намд өгсөн хандивын хэмжээг уг хуулийн этгээд, хуулийн этгээдийн хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газрын өгсөн хандивын нийлбэр дүнгээр тооцно. Намд өгсөн хандивын хэмжээг мөнгөн болон мөнгөн бус хандивын нийлбэр дүнгээр тооцно.</p>	<p>33.8 дахь хэсгийг хассугай.</p>	<p>Хандивын хязгаарлалт цаасан дээр үлдэх эрсдэл: Толгой компани өөрийн хараат болон охин компани, салбаруудаараа дамжуулан намд тэрбум тэрбумаар нь мөнгө цутгах хуулийн цоорхой үүснэ. Мөнгөн бус хандиваар далд санхүүжилт идэвхжинэ.</p>
<p>34.6.12. Уул уурхай, ашигт малтмалын олборлолт, боловсруулах салбарын хуулийн этгээдээс хандив авахыг хориглоно.</p>	<p>34.6.12 дахь заалтыг хассугай.</p>	<p>Төрийг барьцаалах (State Capture) ба Үндэсний аюулгүй байдлын эрсдэл: Санхүүгийн асар их чадамжтай уул уурхайн компаниуд (гэдгээрийн цаана буй гадаад, дотоодын эзэд) намуудыг санхүүжүүлснээр байгаль орчин, стратегийн ордын бодлогыг хувьдаа ашигтайгаар шийдвэрлүүлэх ноцтой аюултай.</p>

ГУРАВ. ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ДОРДУУЛАХГҮЙГЭЭР ПРАКТИК ХҮНДРЭЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ АЛЬТЕРНАТИВ ШИЙДЛҮҮД

Хэрэв улс төрийн намуудад санхүүжилтийн болон үйл ажиллагааны бодит хүндрэл байгаа бол хуулийн ил тод, хариуцлагатай, хараат бус байх суурь үзэл баримтлалыг эвдэхгүйгээр дараах институцийн шийдлүүдийг хуульчлах боломжтой.

1. **Дотоод засаглалын хувьд:** Төлөөллийн төв байгууллагын орон гарсан гишүүдийг дээрээс томилох биш, анхан шатны байгууллагуудын дунд дотоод сунгаа явуулж, хамгийн өндөр санал авсан гишүүнийг автоматаар нөхөн томилдог байх ёстой. Мөн Хяналтын хорооны гишүүнийг намын даргын саналаар биш, зөвхөн тухайн хорооны өөрийнх нь дүгнэлт эсвэл Намын Их хурлын 2/3-ын саналаар чөлөөлдөг байж хараат бус байдал нь хадгалагдана. Мөн Их хурлаас Хяналтын ерөнхий хороог томилох үед нэр дэвшиж байсан гишүүдийг авсан саналаар нь хүлээлгэнд оруулж болно.

ХБНГУ-ын Улс төрийн намуудын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т намын бүх шатны гүйцэтгэх болон хяналтын байгууллагын гишүүдийг зөвхөн нууц санал хураалтаар, доороос нь сонгохыг хуульчилсан байдаг. Дээрээс томилох эсвэл дарга дур мэдэн хяналтын зөвлөлийг өөрчлөхийг хатуу хориглодог.⁵

2. **Орон нутгийн дансны хувьд (Виртуал дэд дансны систем):** Санхүүгийн сахилга батыг алдагдуулахгүйгээр орон нутгийн салбаруудыг санхүүгийн гацаанаас гаргах арга бол “Цахим бүртгэлтэй тусгай зориулалтын зарлагын дэд дансны систем” юм. Хэрэв намын салбарууд данстай байхыг зөвшөөрөх гэж байгаа бол орлогын нэг данстай уясан дэд данс нээж болно. Энэ дэд дансыг СЕХ болон аудитын хяналтыг явуулахад хүндрэлгүй байхаар шийдвэрлэх боломжтой. Их Британи улсын

⁵ ХБНГУ-ын "Улс төрийн намуудын тухай хууль" (Parteiengesetz), 15 дугаар зүйл (§ 15). Цахим холбоос: https://www.gesetze-im-internet.de/partg/_15.html

Улс төрийн намууд, сонгууль, референдумыг тухай хуулийн 5 дугаар бүлэгт намын орон нутгийн салбаруудыг тусдаа бүртгэлтэй данстай байхыг зөвшөөрдөг ч, тэдгээр нь Төв намын санхүүгийн ерөнхий төлөөлөгч болон Сонгуулийн комиссын нэгдсэн цахим системд шууд хяналттай механизмыг хуульчилсан байдаг.⁶

3. **Хандивын тогтолцооны хувьд (Match-funding буюу Хувь тэнцүүлсэн урамшуулал):**

Намуудыг цөөн тооны чинээлэг компаниудаас хараат болгох биш, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд олон улсын практикт байдаг хувь тэнцүүлсэн урамшуулалын системийг нэвтрүүлэх хэрэгтэй. Жишээ нь, иргэнээс авсан 50,000 төгрөгийн жижиг хандив тус бүрд улсын төсвөөс хувь тэнцүүлэн урамшуулал (давхар 50,000₮) олгодог байх. Энэ нь намуудыг олигархиудын халаасанд орох биш, иргэдийн дэмжлэгийг авахын төлөө ажиллах хөшүүрэг болно. Канадын Сонгуулийн тухай хуулиар компани, хуулийн этгээд болон үйлдвэрчний эвлэлээс хандив авахыг БҮРЭН ХОРИГЛОСОН байдаг. Үүний оронд жирийн иргэдийн өгсөн бага дүнтэй хандивыг дэмжих зорилгоор Татварын хөнгөлөлтийн систем (Tax Credit) ашигладаг бөгөөд иргэний эхний 400 хүртэлх долларын хандивын 75%-ийг төрөөс татварын буцаан олголтоор иргэдэд олгодог.⁷ ХБНГУ-ын Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т зааснаар, нэг иргэнээс жилд авсан 3300 хүртэлх еврогийн хандив (эсвэл гишүүний татвар) тус бүрийн 1 евро тутамд төрөөс 0.45 еврог (45%) дүйцүүлэн

тухайн намын дансанд урамшуулал болгож шууд шилжүүлдэг.⁸

4. **Төрийн санхүүжилтийг зарцуулалтыг чанаржуулах:**

Намд өгөх хандивын таазыг нурааж компаниудад хаалгаа нээхийн оронд, сонгуульд авсан саналынх нь хувь хэмжээгээр төрөөс олгодог санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлж болно. Ингэхдээ уг мөнгийг 100 хувь бодлогын судалгаа хийх, хүний нөөцийг сургах, эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоог дэмжих, иргэдийн улс төрийн боловсролыг хөхиүлэн дэмжихэд зориулах хатуу заалттай болгосноор нам жинхэнэ утгаараа бодлогын институци болж төлөвшинө. Францын Улс төрийн санхүүжилтийн ил тод байдлын тухай хуулиар компаниудын хандивыг бүрэн хориглож, төрийн санхүүжилтийг үндсэн эх үүсвэр болгосон. Төрөөс олгох санхүүжилтийн тодорхой хувийг жендэрийн тэгш байдлыг хангасан байдлаар (хэрэв эмэгтэй нэр дэвшигчдийн эзлэх хувь заасан хэмжээнд хүрээгүй бол төрийн санхүүжилтийг шууд хасдаг) олгохоор хуульчилсан байдаг.⁹

5. **Намууд төсвийн соёлд суралцах:** Намууд компаниудын том хандивыг хайж гүйх биш, төсвөөс олгож буй санхүүжилтийг үр ашигтай зарцуулж, өөрийн төсвийг үр ашигтай төлөвлөх, батлах, бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах соёлд суралцах хэрэгтэй. Үүний тулд намын дэргэдэх Бодлогын судалгааны хүрээлэнг хөгжүүлэх, судалгаа шинжилгээ болон иргэдийн улс төрийн боловсролыг дэмжихэд зарцуулдаг байх нь

⁶ Их Британи Улс, Улс төрийн намууд, сонгууль, референдумыг тухай хууль 2000, 5 дугаар бүлэг. Цахим эх сурвалж: [Legislation.gov.uk](http://legislation.gov.uk)

⁷ Канада Улсын "Сонгуулийн тухай хууль" (Canada Elections Act, S.C. 2000, с. 9). Цахим холбоос: <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/E-2.01/> болон "Орлогын татварын тухай хууль" (Income Tax Act, R.S.C., 1985, с. 1 (5th Supp.), s. 127). Цахим холбоос: <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/I-3.3/page-101.html#h-306422>

⁸ ХБНГУ-ын "Улс төрийн намуудын тухай хууль" 1967 (Gesetz über die politischen Parteien / Parteiengesetz - PartG), 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг (§ 18 Abs. 3 Nr. 3). Цахим холбоос: https://www.gesetze-im-internet.de/partg/_18.html

⁹ Loi n° 88-227 du 11 mars 1988 relative à la transparence financière de la vie politique [Law No. 88-227 of March 11, 1988 on Financial Transparency of Political Life], Journal Officiel de la République Française [J.O.], March 12, 1988, available at <https://www.legifrance.gouv.fr/loda/id/JORFTEXT000000321646>.

намыг санхүүгийн сахилга баттай, бодлогын институци болгож төлөвшүүлнэ. ХБНГУ-ын Улс төрийн намуудын тухай хуулиар намдын дэргэдэх улс төрийн сангуудыг (Жишээ нь: Конрад Аденауэр, Фридрих Эбертийн сан гэх мэт) улсын төсвөөс тусгайлан санхүүжүүлдэг бөгөөд эдгээр мөнгийг намын

өдөр тутмын урсгал зардал эсвэл сонгуулийн сурталчилгаанд зарцуулахыг хатуу хориглодог. Төсвийн мөнгийг зөвхөн иргэний боловсрол, бодлогын судалгаанд зарцуулснаар намууд төсвийн сахилга бат, соёлд суралцаж, улс төрийн бодлогын өндөр чадамжтай болж төлөвшинө.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ: ИНСТИТУЦИЙН УХРАЛТ БА СИСТЕМИЙН ЭРСДЭЛ

АН-аас боловсруулсан Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн суурь үзэл баримтлал болон Монгол Улсын ардчилсан институцийн хөгжлийн чиг хандлагатай зөрчилдөж байна. Мөн Улс төрийн намын тухай хуулийн амин сүнс болсон санхүүгийн ил тод байдал, хяналт, намын дотоод засаглал дахь эрх мэдлийн тэнцвэрт байдал, мөнгөний нөлөөллийг хязгаарлах зэрэг засаглалын суурь механизмыг бүхэлд нь сулруулж, эрх зүйн зохицуулалтыг дордуулсан шинжтэй байна.

Дүн шинжилгээнээс үзэхэд, улс төрийн намуудад тулгарч буй орон нутгийн санхүүжилтийн болон үйл ажиллагааны практик хүндрэлийг хандивын босгыг 10 дахин нэмэгдүүлж, уул уурхайн салбарын хоригийг цуцлах замаар шийдвэрлэх боломжгүй юм. Энэхүү алхам нь намуудыг олон нийтийн оролцооноос тусгаарлаж, чинээлэг бүлгүүдийн ашиг сонирхлыг хамгаалсан “Картель

нам” болон плутократи тогтолцоо руу шилжих институцийн занганд оруулах өндөр эрсдэлтэй байна.

Улс төрийн намуудын өрсөлдөх чадавхыг сайжруулах гарц нь хаалттай бүлэглэлийг дэмжих биш, харин олон улсын жишгийн дагуу санхүүгийн дэд дансны систем бүхий цахим шилэн хяналт, иргэдийн жижиг хандив цуглуулсан намыг урамшуулах татварын уян хатан системийг нэвтрүүлэх явдал юм. Түүнчлэн, зөвхөн төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг бус орлогоо бүхэлд нь бодлогын судалгаа, гишүүдийн болон иргэний боловсролд зарцуулж хэвших замаар намыг санхүүгийн сахилга бат, “төсвийн соёл”-д суралцах зэрэг институцийн өөрчлөлтийг хийх шаардлагатай байна. Энэхүү бүтцийн альтернатив шийдлүүдийг сонгох нь намуудыг олигархижуулах үйл явцаас сэргийлж, бодлогын институци болгон төлөвшүүлэх, улмаар Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хамгаалах боломж юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ.

1. News.mn. (2024, November 27). “Хуулийн хэрэгжилтийг хойшлуулахгүй бол Монголд нам үлдэхгүй.” <https://news.mn/r/2766504/>
2. Конрад Аденауэр сан. (2020). ХБНГУ-ын Улс төрийн намуудын тухай хууль. https://www.kas.de/documents/268650/0/PartG_mongolisch.pdf/24dd5b2c-0b0a-2463-168b-8d9e72113df9
3. Монгол Улсын Их Хурал. (2025). Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай (Тогтоол №126). Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (Legalinfo.mn). <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17435085372392>
4. Нээлттэй Нийгэм Форум. (2025). Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд өгөх шүүмж (Хуулийн шүүмж №50). <https://forum.mn/post/168670>
5. Parliament.mn. (2025, September 26). “Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барилаа.” <https://www.parliament.mn/nn/75750/>
6. Canada Elections Act, S.C. 2000, с. 9. <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/E-2.01/>
7. Income Tax Act, R.S.C., 1985, с. 1 (5th Supp.). <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/I-3.3/page-101.html#h-306422>
8. Loi n° 88-227 du 11 mars 1988 relative a la transparence financiere de la vie politique. (1988, March 12). Journal Officiel de la Rйpublique Francaise. <https://www.legifrance.gouv.fr/loda/id/JORFTEXT000000321646>
9. Political Parties, Elections and Referendums Act 2000, с. 41. <https://legislation.gov.uk/ukpga/2000/41/contents>

- ☑ Байр суурь
- ☑ Дүн шинжилгээ

МОНГОЛ

ЭРДЭНЭБИЛЭГИЙН
ГЭРЭЛТ-ОД

2022



Эрдэнэбилэгийн Гэрэлт-Од

Улс төрийн нам, намын дотоод ардчилал, сонгууль болон улс төр дэх жендэрийн тэгш байдлын чиглэлээр 2000-аад оноос эхлэн хорь гаруй жил судалгаа хийж буй юм. Судлаач сонгуулийн тогтолцооны шинэчлэл, намын төлөвшил, дотоод ардчилал болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог эрх зүйн шинэчлэлээр дамжуулан хэрхэн дэмжих вэ гэдэг асуудлыг голчлон судалдаг. 2009 онд “Монгол дахь улс төрийн намуудын дотоод ардчиллын төлөвшлийн асуудал: 1990 оноос хойш” сэдвээр улс төр судлалын докторын (Ph.D) зэрэг хамгаалж, судалгааны бүтээлээ 2013 онд “Улс төрийн намын дотоод ардчилал” нэртэйгээр ном болгон хэвлүүлсэн.

Э.Гэрэлт-Од нь судалгааны ажлын зэрэгцээ МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимд багшилдаг. Мөн 2010 оноос хойш УИХ-аас байгуулсан Улс төрийн намын тухай хуулийн ажлын хэсгүүдэд ажилласнаас гадна 2010-2013, 2021-2025 онуудад Монгол дахь НҮБХХ-ийн төслүүдэд менежер, техникийн зөвлөхөөр ажилласан. Ингэхдээ сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх, намын хуулийн шинэчлэлийг дэмжих бодлого, нөлөөллийн ажлуудыг амжилттай удирдаж, зохион байгуулсан.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 14240,
Сүхбаатар дүүрэг, Л.Түдэвийн гудамж-5/3
Утас: 976-76113207
Факс: 976-11-324857
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn